

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 10-ны өдөр

Дугаар 03/03

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.2, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2026 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хотод "Хасвуу" плазагийн хурлын танхимд хуралдуулсугай.

Хоёр. Хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй: (i) Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; (ii) Компанийн 2025 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг хувиарлахгүй тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах; (iii) Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох; (iv) Компанийн ТУЗ-ийн 2026-2027 оны ТУЗ-ийн цалин урамшуулал болон зардлыг батлах;

Гурав. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 03-ний өдрөөр тогтоосугай.

Дөрөв. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөр тогтоон, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-д нийцүүлэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 2026 оны 03 дугаар сарын 16 болон 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд зарласугай.

Тав. Хувьцаа эзэмшигчид нь Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, 2025 оны үйл ажиллагааны тайлан, Компанийн 2026 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл болон холбогдох бусад мэдээлэлтэй танилцаж болно.

Зургаа. Хурлын даргаар Г. Бэхбатыг томилсугай. Тооллогын комиссын даргаар Ц.Баярбаатар, гишүүнээр М.Баярманла нарыг тус тус томилсугай.

Долоо. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг хавсралтаар баталсугай.



Г.БЭХБАТ

“ДСЦТС” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 03-р
сарын 10-ний өдрийн №03/03 дугаар
тогтоолын хавсралт



“ДСЦТС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо “Хасвуу Плаза”-гийн хурлын танхимд болно.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2026 оны 04-р сарын 03-ний өдөр

Хувьцаа эзэмшигч этгээдийн нэр:

Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо:

Бүртгэгдсэн үнэт цаасны компанийн нэр:

Санал хураалтаар шийдвэрлэх асуудал:

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;

А. Зөвшөөрсөн Б. Татгалзсан В. Түдгэлзсэн

Нэмэлт тэмдэглэл:

2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

3. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2026.05.01-2027.04.30 оны цалин урамшуулал болон зардлыг батлах


А. Зөвшөөрсөн Б. Татгалзсан В. Түдгэлзсэн

Нэмэлт тэмдэглэл

Гарын үсэг: _____

Саналын хуудас хүргүүлсэн огноо:

Брокер, дилерийн компани: _____



**"ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Хаяг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо "Хасвуу Плаза"-гийн хурлын танхимд болно.

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах
бүртгэлийн өдөр:** 2025 оны 04-р сарын 03-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал: (i) Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; (ii) Компанийн 2025 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг хувиарлахгүй тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах; (iii) Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох; (iv) Компанийн ТУЗ-ийн 2026-2027 оны ТУЗ-ийн цалин урамшуулал болон зардлыг батлах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2026 оны 04 дүгээр сарын 03-ний өдрөөс эхлэн ажлын цагаар өөрийн үйлчилгээ авч буй үнэт цаасны компаниуд болон "Хасвуу Плаза"-гийн хурлын танхимд ирж танилцах боломжтой.

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комисс
Утас: 11-318998, 99082623

Цахим шуудан: kholboos@yahoo.com

Санхүүгийн зохицуулах хорооны

2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн

377 дугаар тогтоолоор баталсан

“Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн

хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“ДСЦТС” ХК
Хаяг:	Дархан -Уул аймгийн Дархан сум, 3-р баг, өөрийн байр
Хурал хуралдах өдөр, цаг:	2025 оны 04 дүгээр дугаар сарын 21-ний өдөр 14:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Хасвуу Плаза байрны хурлын өрөө
Хурлын төрөл:	Ээлжит: ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ
Хурал зарлагч:	ТУЗ – ТУЗ ЗАРЛАСАН
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2026 оны 03 дугаар сарын 10
Олон нийтэд зарлах огноо:	2026.03.16 болон 2026.03.31
Бүртгэлийн өдөр:	2026.04.03
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2023.04.03
Хүргүүлсэн огноо:	
Хурлын даргын нэр:	Г.Бэхбат
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Тооллогын комиссын даргаар Ц.Баярбаатар, гишүүнээр М.Баярманла
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	Хурал хуралдуулах тухай шийдвэр, Санхүүгийн тайлан Аудитын дүгнэлт
Баримт бичгийн хуудасны тоо:	 ширхэг
	 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА



/Г.БЭХБАТ/

2026 оны 03 дугаар сарын 13 –ны өдөр